



ХЭНТИЙ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 01 сарын 13 өдөр

Дугаар А/02

Дэлгэрхаан сум

Багш ажилчдын цалин хөлс шинэчлэн
тогтоох тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 33.3.1, 33.3.7, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам", хоёрдугаар хавсралт "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдад нэмэгдэл хөлс олгох журам"-ын 4.3 дахь хэсэг, дөрөвдүгээр хавсралт "Төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам", 5 дугаар хавсралт "Төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох нийтлэг журам", 6 дугаар хавсралт "Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам", Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоол, 84 дүгээр тогтоолын 3, 6 дугаар хавсралт, 238 дугаар тогтоолын 7, 11 дүгээр хавсралт, Сургуулийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.3.1, 3.3.3.1, байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын 2 дугаар зүйлийн 2.2.2, 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Багш, ажилтанд олгох үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлсийг шинэчлэн тогтоож хавсралтаар баталсугай.
2. Багш, ажилтны үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлсийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу бодож олгохыг нягтлан бодогч (Д.Энхсаруул)-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт шалгалтын багт даалгасугай.

ЗАХИРАЛ  Ш.ЦЭРӨНДУЛАМ

